

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/08.

Арвайхээр

Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар (КОВИД-19), амьсгалын замын хүнд халдварын тандалт, судалгаа, эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангах зохицуулах баг томилох тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Түр заавар шинэчлэн батлах тухай” А/36 дугаар тушаалын 3.6.3, 3.6.5 дахь заалт, 2020 оны “Томуу, томуу төст өвчний бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж батлах тухай” А/482 дугаар тушаал, 2020 оны “Түр заавар батлах тухай” А/583 дугаар, 2008 оны “Менингококкт халдвартай тэмцэх, сэргийлэх арга хэмжээг эмчимжүүлэх тухай” А/37 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар (КОВИД-19), амьсгалын замын хүнд халдварын тандалт, судалгаа, эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангах зохицуулах багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах мэргэжилтнүүдийн хуваарийг гуравдугаар, томуу, томуу төст өвчлөлийн мэдээг дөрөвдүгээр, орны мэдээг тавдугаар, нас баралтын мэдээг зургаадугаар, назофарингитын үзлэгийн мэдээг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар (КОВИД-19), амьсгалын замын хүнд халдварын үеийн тандалт, хариу арга хэмжээг холбогдох тушаал, шийдвэрийн хүрээнд цаг хугацаанд нь чанартай, бүрэн гүйцэт хийж гүйцэтгэхийг багийн нийт гишүүдэд даалгасугай.

3. Багуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа)-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/25 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

18800 014

My Doc.tushaal/EMG/

  
 Эрүүл мэндийн газрын даргын  
 2022 оны 03 дугаар сарын 17-ны  
 өдрийн 4/08 дугаар тушаалын  
 нэгдүгээр хавсралт

**ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН, КОРОНАВИРУСТ ХАЛДВАР  
 (КОВИД-19), АМЬСГАЛЫН ЗАМЫН ХҮНД ХАЛДВАРЫН  
 ТАНДАЛТ, СУДАЛГАА, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН  
 БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОХИЦУУЛАХ  
 БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Д/д	Овог	Нэр	Албан тушаал	Холбоо барих утасны дугаар	Ажиллах чиг үүрэг
<b>Тандалт судалгаа, хариу арга хэмжээг зохион байгуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах баг</b>					
1.	Мангалжав	Золзаяа	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга	88108948	Багийн ахлагч
2.	Юндэн	Ичинноров	Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга	99038205	Багийн гишүүн
3.	Баясгалан	Ариунзаяат	Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн	88055856	Багийн гишүүн
4.	Мөнхбат	Ганцэцэг	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн	80668103	Багийн гишүүн
5.	Батжаргал	Оюунчимэг	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн	88689110	Багийн гишүүн
6.	Цэдэнсодном	Рэгзэдмаа	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн	90166929	Багийн гишүүн
7.	Энхбаатар	Лхагвадулам	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн	89052036	Багийн гишүүн
8.	Жанчивбямба	Мягмар	Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн тархвар судлаач эмч	99892348	Багийн гишүүн
<b>Мэдээ, мэдээллэл цуглуулах баг</b>					
9.	Гөлөгтөмөр	Надмидсүрэн	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тархвар судлаач	89298499	Багийн гишүүн
10.	Болоо	Долзодмаа	Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн	88715577	Багийн гишүүн
11.	Гантуяа	Энхтуул	Түшигдөлгөөн өрхийн эрүүл мэндийн төв	88339791	Багийн гишүүн
12.	Даваасүрэн	Цэнд-Аюуш	Уянсэтгэл өрхийн эрүүл мэндийн төв	89719985	Багийн гишүүн
13.	Сангижаргал	Ариунсүвд	Нарны дөш өрхийн эрүүл мэндийн төв	89062199	Багийн гишүүн

Эрүүл мэндийн газрын даргын  
2022 оны 03 дугаар сарын 17-ны  
өдрийн 4/2 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН, КОРОНАВИРУСТ  
ХАЛДВАР (КОВИД-19), АМЬСГАЛЫН ЗАМЫН ХҮНД  
ХАЛДВАРЫН ТАНДАЛТ, СУДАЛГАА, ЭМНЭЛГИЙН  
ТУСЛАМЖИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ  
ЗОХИЦУУЛАХ БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхий дахиныг хамарсан 1918 оны томуугийн цар тахлаас хойш 100 гаруй жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд цар тахлын 3 удаагийн дэгдэлт гарч 55 сая гаруй хүн ам насаа алджээ. Тухайлбал 2009 онд томуугийн А хүрээний H1N1 шинэ вирусийн халдвар гарч, дэлхий дахинд 200 сая хүн, манай улсад 50 мянга гаруй хүн өвчилсөн байдаг.

Томуу, томуу төст өвчин нь богино хугацаанд олон хүнийг хамран өвчлүүлж, хүндрэл, эндэгдэлд хүргэдэгээрээ нийгмийн эрүүл мэндийн анхаарал татсан асуудал хэвээр байна. Тухайлбал дэлхийд жил бүр 3-5 сая хүн томуугийн улмаас хүндэрч, 290,000-650,000 хүн нас барж байгаа талаар мэдээлж байна.

Монгол улсын хэмжээнд 12 дугаар долоо хоногийн байдлаар амбулаториор 192,363 хүн үйлчлүүлсний 25,342 нь ТТӨ ба 10,000 хүн амд 91.2 тохиолдол, 16 хүртэлх насны 3,868 хүүхэд эмнэлэгт хэвтэн эмчлүүлсний 68.1% (2,635) нь АЗЦХХ-ын шалтгаантай байгаа ба улирлын болон томуугийн цартахлын эрсдэлийн үнэлгээгээр УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ ДЭГДЭЛТИЙН ТҮВШИНД байна. Харин манай аймгийн хэмжээнд 7228 хүн амбулаториор үйлчлүүлсний 1204 (16.6%) тохиолдол томуу, томуу төст өвчин бүртгэгдэж өмнөх долоо хоногоос 1.3%-аар, өмнөх оны мөн үеэс 10.9%-аар өссөн байна. 10,000 хүн амд 102.7 тохиолдол томуу, томуу төст өвчин, 10,000 хүн амд ноогдох АЗЦХХ 22 байгаа нь улирлын болон томуугийн цартахлын эрсдэлийн үнэлгээгээр АЙМГИЙН ХЭМЖЭЭНИЙ ДЭГДЭЛТИЙН ТҮВШИНД -д байна.

Аймгийн хэмжээнд коронавируст халдварын анхны тохиолдол 2021 оны 03 дугаар сарын 22-нд бүртгэгдсэнээс хойш 4 дэхь давлагаа 2022 оны 01 дүгээр сарын 04-ны өдрөөс эхлэн 2-р сарын 04-ний өдрийг хүртэл үргэлжилж 4960 тохиолдол нэмэгдсэнээр 2022 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 22453 тохиолдол бүртгэгдээд байна.

Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар /КОВИД-19/, амьсгалын замын хүнд халдварын тандалтыг өргөжүүлсэнээр бүртгэгдсэн тохиолдол бүрийг 24 цагийн дотор судалж, хавьтлыг тогтоох, хяналтад авах нь халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн байгууллагуудын тандалтын багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах, лабораторийн шинжилгээг тогтмолжуулах, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээллээр хангах, нотолгоонд суурилсан хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хоёр. Зорилго

- 2.1 Аймгийн хэмжээнд бүртгэгдэж буй томуу, томуу төст өвчин, амьсгалын замын хүнд халдварын үеийн эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангах, Коронавируст халдвар (КОВИД-19), амьсгалын замын хүнд халдварын

батлагдсан тохиолдлын тархвар зүйн судалгааг хийж, тандалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн хариу арга хэмжээ үзүүлэх чадавхийг сайжруулах, мэргэжил арга зүйгээр хангах, нотолгоонд суурилсан нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд оршино.

#### Гурав. Багуудын ажиллах журам

### 3.1 Тандалт судалгаа, хариу арга хэмжээг зохион байгуулах, эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангах баг:

- 3.1.1 Багийн гишүүдийг мэргэжил арга зүйгээр хангах ажлыг багийн ахлагч хариуцна;
- 3.1.2 Багийн ахлагч нь тухайн өдөрт бүртгэгдсэн коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлыг багийн гишүүдэд хуваарилан, тандалт судалгаа хийх гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана;
- 3.1.3 Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар (КОВИД-19), амьсгалын замын хүнд халдварын үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, тоног төхөөрөмжийн ашиглалт, хэрэгцээг тооцож нөөц бүрдүүлэх, нэмэлтээр ор дэлгэх бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах;
- 3.1.4 Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар (КОВИД-19), амьсгалын замын хүнд халдварын оношилгоо, эмчилгээний удирдамжийн хэрэгжилтийг үнэлэх, зөвлөмжөөр хангах;
- 3.1.5 Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар (КОВИД-19), амьсгалын замын хүнд халдварын өвчлөл, нас баралт, орны мэдээг өдөр тутам хариуцсан сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлгээс авч, 7 хоног тутам нэгдсэн дүгнэлт хийх, эргэн мэдээ, зөвлөмжөөр хангах;
- 3.1.6 Хариуцсан сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ирцийн мэдээг авах, хяналт тавих,
- 3.1.7 Хариуцсан сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагат 14 хоног тутам хамар залгиур (назофарингит)-ын үзлэгийг зохион байгуулах чиглэл өгч, назофарингитын үзлэгийн мэдээг 7 хоног тутам авах, өвчлөлтэй хүүхдүүдийг эмчлэн, эрүүлжүүлэх мэргэжил арга зүйгээр хангах;
- 3.1.8 Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар (КОВИД-19), амьсгалын замын хүнд халдварын өдөр тутмын мэдээнд үндэслэн иргэд, олон нийтэд шаардлагатай мэдээ, мэдээллийг тогтмол хүргэх ажлыг сум, өрхийн эмч нартай хамтран зохион байгуулах;
- 3.1.9 Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын судалгааг тухай бүрт нь Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/36 дугаар тушаалын дагуу тархвар судлалын асуумжийн дагуу хийж гүйцэтгэнэ;
- 3.1.10 Коронавируст халдвар (КОВИД-19), амьсгалын замын хүнд халдварын батлагдсан тохиолдол болон хавьтлын тархвар судлалын мэдээллийг 24 цагийн дотор бүрэн гүйцэд [www.covid.uvurkhangai.gov.mn](http://www.covid.uvurkhangai.gov.mn) цахим бүртгэлд оруулна;
- 3.1.11 Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалтын сорьц тээвэрлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, багийн гишүүд хариуцсан сум, өрхийн эрүүл мэндийн төвдүүдэд хяналт тавьж, 7 хоног бүр тогтмол сорьц тээвэрлэх ажлыг зохион байгуулах;

- 3.1.12 Томуу, томуу төст өвчний эрсдэлийн үнэлгээнд үндэслэн хариу арга хэмжээг хариуцсан сумдад Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/482 дугаар тушаалд заасны дагуу зохион байгуулах чиглэл өгөх;
- 3.1.13 Хариуцаж буй сумдаас эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг гарган, улирлын томуугийн үед багийн эмчийн үзлэгийн давтамжийг нэмэгдүүлэх, хяналт тавин ажиллах;
- 3.2 Мэдээ, мэдээллэл цуглуулах багийн үүрэг**
- 3.2.1 Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар (КОВИД-19), амьсгалын замын хүнд халдварын өвчлөлийн амбулаторийн үзлэгийн мэдээг өдөр бүр авч, эрүүл мэндийн газарт цаг хугацаанд нь бүрэн гүйцэт, үнэн зөв мэдээлэх;
- 3.2.2 Коронавируст халдвар (КОВИД-19), амьсгалын замын хүнд халдварын хавьтлыг бүрэн тогтоон, бүртгэх;
- 3.2.3 Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар (КОВИД-19), амьсгалын замын хүнд халдварын нас баралт, орны мэдээг өдөр бүр, бүрэн гүйцэт, үнэн зөв авч эрүүл мэндийн газарт мэдээлэх;
- 3.2.4 14 хоногт нэг удаа ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад назофарингитын үзлэгийг хийж, өвчлөлтэй хүүхдийг эмчлэн эрүүлжүүлэх, үзлэгийн мэдээг 7 хоног бүр тогтмол, бүрэн гүйцэт гарган, хяналт тавьж буй мэргэжилтэнд хүргүүлэх;
- 3.2.5 Харьяа эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг гарган, улирлын томуугийн үед багийн эмчийн үзлэгийн давтамжийг нэмэгдүүлэх;
- 3.2.6 Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн вирусологийн лабораторийн үйл ажиллагааг тогтмолжуулах, томуу, томуу төст өвчний вирус илрүүлэх шинжилгээг тогтмол хийх;
- 3.2.7 Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар (КОВИД-19), амьсгалын замын хүнд халдварын өвчлөлд дүгнэлт хийх, хариу арга хэмжээг авах;
- 3.2.8 Иргэдэд томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар (КОВИД-19), амьсгалын замын хүнд халдвараас урьдчилан сэргилэх хамгаалах талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах;
- 3.2.9 Томуу, томуу төст өвчин, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тандалтын сорьцыг цуглуулах;
- 3.2.10 Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эмч нарыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах, эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд дотоодын сургалтыг зохион байгуулах;

#### Дөрөв. Хариуцлага

- 4.1 Коронавируст халдвар (ковид-19), томуу, томуу төст өвчин, амьсгалын замын хүнд халдварын тандалт, судалгаа, эмнэлгийн тусламжийн бэлэн байдалыг хангах зохицуулах журамд заасан үүргийг хэрэгжүүлээгүй 3 буюу түүнээс дээш сануулга авсан тохиолдолд зохицуулагчийн шийдвэрээр багийн гишүүнийг бүрэлдэхүүнээс чөлөөлнө.

Эрүүл мэндийн газрын даргын  
2022 оны 03 дугаар сарын 17-ны  
өдрийн 4/18 дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт

ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН, КОРОНАВИРУСТ  
ХАЛДВАР (КОВИД-19), АМЬСГАЛЫН ЗАМЫН  
ХҮНД ХАЛДВАРЫН ҮЕД СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВ, ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭМНЭЛГҮҮДЭД  
МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАЖ АЖИЛЛАХ  
МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ХУВААРЬ

№	Овог	Нэр	Хяналт тавих сумдын нэр	Холбоо барих утасны дугаар
1.	Мангалжав	Золзаяа	Бат-Өлзий сум	88108948
			Баянгол сум	
			Чинмэнд хувийн хэвшлийн эмнэлэг	
2	Юндэн	Ичинноров	Баян-Өндөр сум	99038205
			Богд сум	
			Ачтан-Ирээдүй хувийн хэвшлийн эмнэлэг	
3	Цэдэнсодном	Рэгзэдмаа	Бүрд сум	90166929
			Тарагт сум	
			Гучин-Ус сум	
4	Баясгалан	Ариунзаяат	Есөнзүйл сум	88055856
			Хужирт сум	
			Ариунсанаа хувийн хэвшлийн эмнэлэг	
5	Энхбаатар	Лхагвадулам	Зүүнбаян-Улаан сум	89052036
			Өлзийт сум	
			Арвайхээр сум	
6	Мөнхбат	Ганцэцэг	Сант сум	80668103
			Хайрхандулаан сум	
			Төгрөг сум	
7	Батжаргал	Оюунчимэг	Уянга сум	88689110
			Нарийнтээл сум	
			Баруунбаян-Улаан сум	
8	Жанчивбямба	Мягмар	Хархорин сумын нэгдсэн эмнэлэг	99892348
			Энэрэл-Хархорин өрхийн эрүүл мэндийн төв	

























16	Хайрхандулаан																			
17	Хархорин																			
18	Хужирт																			
19	Нарны Деш																			
20	Уянсэтгэл																			
21	Энэрэлт Хархорин																			
22	Түшигдөлгөөн																			
23	БОЭТ																			
24	ЗХ-ний 256-р анги																			
	Дүн																			

-oOo-